



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн ирээдүй цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Шинжлэн Магадлахуй ЭЗШ
Аудит ХХК-ийн

Гүйцэтгэх захирал С.Оргил

Утас: 99197346

Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 138

танай _____-ны № _____-т

Г АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН
“ИРЭЭДҮЙ” ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ХОРЛООСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ирээдүй цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,020,269.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, өмнөх оны үлдэгдэл 86,730.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,069,162.3 мянган төгрөгийг зарцуулж 37,816.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 үндсэн зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	86,730,464.0	37,816,864.4
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	86,730,464.0	37,816,864.4
3121	Төгрөг	86,730,464.0	37,816,864.4
31211	Төрийн сангийн харилцах	86,730,464.0	37,816,864.4
33	АВЛАГА	-	6,741,111.2
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	6,741,111.2
35	БАРАА МАТЕРИАЛ	28,378,030.0	36,778,030.0
351	Түүхий эд материал	3,608,220.0	3,608,220.0
3511	Тусгай зориулалттай материал	3,608,220.0	3,608,220.0
354	Хангамжийн материал	24,769,810.0	33,169,810.0
3541	Бичиг хэргийн материал	687,560.0	2,440,960.0
3542	Аж ахуйн материал	20,105,550.0	29,362,650.0
3544	Түлш, шатах тослох материал	3,139,500.0	713,000.0
3545	Барилгын засварын материал	770,000.0	-
3546	Хүнсний материал	67,200.0	653,200.0
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,108,494.0	81,336,005.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	638,785,462.5	629,940,980.6
392	Биет хөрөнгө	638,785,462.5	629,940,980.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	664,000,000.0	664,000,000.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,199,999.9)	(59,266,666.5)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,988,913.0	24,745,545.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,282,243.8)	(8,970,307.5)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,831,971.9	15,728,475.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,391,628.8)	(6,814,866.1)
39217	Ном	838,450.0	518,800.0
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	638,785,462.5	629,940,980.6
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	753,893,956.5	711,276,986.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,463,500.0
413	Өглөг	-	7,463,500.0
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	7,463,500.0
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	7,463,500.0
51	Засгийн газрын хувь оролцоо	753,893,955.5	703,813,485.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,849,236.0	52,849,236.0
51101	Өмч: - төрийн	52,849,236.0	52,849,236.0
512	Хуримтлагдсан үр дүн	694,556,604.9	644,476,134.6
5121	Өмнөх үеийн үр дүн	694,556,604.9	694,556,604.9
5122	Тайлант үеийн үр дүн	-	(50,080,470.3)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,488,114.7	6,488,114.7
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	753,893,955.5	703,813,485.2
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	753,893,955.5	711,276,985.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	956,055,500.0	1,020,269,100.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	893,317,300.0	974,930,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	893,317,300.0	974,930,600.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,738,200.0	45,338,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,738,200.0	45,338,500.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,486,500.0	33,525,200.0
120	Нийтлэг татварын бус орлого	10,486,500.0	33,525,200.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	525,000.0	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,961,500.0	5,411,400.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		28,113,800.0
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	966,542,000.0	1,053,794,300.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	919,727,672.0	1,099,815,720.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,586,660.8	1,099,795,348.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,323,492.3	796,477,000.0
210101	Үндсэн цалин	457,655,825.6	520,079,097.0
210102	Нэмэгдэл	158,912,431.3	223,190,309.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,578,160.0
210104	Урамшуулал	39,755,235.5	41,629,434.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,014,500.0	95,021,888.8
210201	Тэтгэврийн даатгал	57,809,800.0	62,280,188.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,801,200.0	8,185,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,400,600.0	4,092,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,400,600.0	4,092,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,602,300.0	16,370,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,056,395.9	40,744,628.0
210301	Гэрэл, цахилгаан	1,309,394.0	2,173,328.0
210302	Түлш, халаалт	25,938,000.0	34,247,000.0
210303	Цэвэр, бохир ус	3,809,001.9	4,324,300.0
2104	Хангамж, бараа материалын зардал		14,313,900.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		14,313,900.0
2105	Нормативт зардал	79,689,626.0	93,077,300.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,955,000.0	
210502	Хоол, хүнс	76,734,626.0	93,077,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,966,350.0	12,913,500.0
210604	Урсгал засвар	12,966,350.0	12,913,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,773,100.0	5,127,100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,773,100.0	5,127,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,763,196.6	42,120,031.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,414,651.0	16,108,799.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,886,150.0	8,738,800.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,462,395.6	17,272,431.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,011.1	20,372.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	141,011.1	20,372.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	141,011.1	20,372.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	919,727,672.0	1,099,815,720.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,814,328.1	(46,021,420.3)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,059,050.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		319,650.0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		3,739,400.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(4,059,050.0)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	46,814,328.1	(50,080,470.3)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	956,580,500.0	1,020,269,100.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	525,000.0	-
120	Нийтлэг татварын бус орлого	525,000.0	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	525,000.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	956,055,500.0	1,020,269,100.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	893,317,300.0	974,930,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	893,317,300.0	974,930,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,738,200.0	45,338,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,738,200.0	45,338,500.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	909,932,732.6	1,069,182,699.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	909,932,732.6	1,069,182,699.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,791,721.5	1,069,162,327.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,314,906.6	796,477,000.0
210101	Үндсэн цалин	457,647,239.8	520,079,097.0
210102	Нэмэгдэл	158,912,431.3	223,190,309.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,578,160.0
210104	Урамшуулал	39,755,235.5	41,629,434.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,014,500.0	101,763,000.0
210201	Тэтгэврийн даатгал	57,809,800.0	69,021,300.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,801,200.0	8,185,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,400,600.0	4,092,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,400,600.0	4,092,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,602,300.0	16,370,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,641,188.9	38,318,128.0
210301	Гэрэл, цахилгаан	1,309,394.0	2,173,328.0
210302	Түлш, халаалт	39,522,793.0	31,820,500.0
210303	Цэвэр, бохир ус	3,809,001.9	4,324,300.0
2105	Нормативт зардал	76,574,126.0	93,663,300.0
210502	Хоол, хүнс	76,574,126.0	93,663,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,956,000.0	7,000,000.0
210604	Урсгал засвар	17,956,000.0	7,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,773,100.0	5,127,100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,773,100.0	5,127,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,517,900.0	26,813,799.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,121,500.0	18,563,299.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,396,400.0	8,250,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,011.1	20,372.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	141,011.1	20,372.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	141,011.1	20,372.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	46,647,767.4	(48,913,599.6)
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	46,647,767.4	(48,913,599.6)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	86,730,464.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	37,816,864.4

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ирээдүй цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл				
4-08	Тайлант үеийн үр дүн				
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,849,236.0	6,488,114.7	694,556,604.9	753,893,955.5
4-08	Тайлант үеийн үр дүн			(50,080,470.3)	(50,080,470.3)
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,849,236.0	6,488,114.7	644,476,134.6	703,813,485.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,101,515,800.0	1,020,269,100.0	81,246,700.0	92.6	
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,056,177,300.0	974,930,600.0	81,246,700.0	92.3	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,056,177,300.0	974,930,600.0	81,246,700.0	92.3	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,338,500.0	45,338,500.0	0.0	100	
132001	Орон нутгийн төсвөөс	45,338,500.0	45,338,500.0	0.0	100	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,264,900.0	0.0	80,264,900.0		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	80,264,900.0	0.0	80,264,900.0		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,181,780,700.0	1,020,269,100.0	161,511,600.0	86.3	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,515,800.0	1,069,162,327.6	32,353,472.4	97.1	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,515,800.0	1,069,162,327.6	32,353,472.4	97.1	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	821,391,500.0	796,477,000.0	24,914,500.0	97	
210101	Үндсэн цалин	560,503,300.0	520,079,097.0	40,424,203.0	92.8	
210102	Нэмэгдэл	241,983,300.0	223,190,309.0	18,792,991.0	92.2	
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,578,160.0	-11,578,160.0		
210104	Урамшуулал	18,904,900.0	41,629,434.0	-22,724,534.0	220	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,055,400.0	101,763,000.0	292,400.0	99.7	
210201	Тэтгэврийн даатгал	69,220,100.0	69,021,300.0	198,800.0	99.7	
210202	Тэтгэмжийн даатгал	8,208,900.0	8,185,500.0	23,400.0	99.7	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,104,400.0	4,092,700.0	11,700.0	99.7	
210204	Ажилгүйдлийн даатгал	4,104,400.0	4,092,700.0	11,700.0	99.7	
210205	Эрүүл мэндийн даатгал	16,417,600.0	16,370,800.0	46,800.0	99.7	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,338,500.0	38,318,128.0	20,372.0	100	
210301	Гэрэл, цахилгаан	4,014,200.0	2,173,328.0	1,840,872.0	54.1	
210302	Түлш, халаалт	30,000,000.0	31,820,500.0	-1,820,500.0	106	
210303	Цэвэр, бохир ус	4,324,300.0	4,324,300.0		100	
2105	Нормативт зардал	100,789,400.0	93,663,300.0	7,126,100.0	92.9	
210502	Хоол, хүнс	100,789,400.0	93,663,300.0	7,126,100.0	92.9	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.0	7,000,000.0	0.0	100	
210604	Урсгал засвар	7,000,000.0	7,000,000.0	0.0	100	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,127,200.0	5,127,100.0	100.0	100	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,127,200.0	5,127,100.0	100.0	100	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,813,800.0	26,813,799.6	0.4	100	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,563,300.0	18,563,299.6	0.4	100	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,250,500.0	8,250,500.0	0.0	100	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,101,515,800.0	1,069,162,327.6	32,353,472.4	97.1	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0	86,730,464.0	-86,730,464.0	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0	37,816,864.4	-37,816,864.4	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО		25	55	-30	220
6	Удирдах ажилтан			2	-2	

7	Гүйцэтгэх ажилтан	11	27	-16	245
8	Үйлчлэх ажилтан	14	26	-12	186
9	Гэрээт ажилтан	2	2	0	100
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	190	190	0	100
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	190	190	0	100
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	190	190	0	100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 23,094.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар акталсан хөрөнгийн элэгдэл 23,094.5 мянган төгрөгийг хасаагүйгээс үндсэн хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй тусгасныг аудитын явцад залрууллаа. Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 14.4.1, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Залруулаагүй нийт 11,211.8 мянган төгрөгийн зөрчилд² зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй асуудлын материаллаг зөрчил нь 11,211.8 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 12,392.1 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,470,700.0 төгрөгийн бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.1.2 Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 6,741,111.18 төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулж ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Цахим худалдан авалттай холбоотой	1	4,470.7			1	4,470.7				
Авлагатай холбоотой	1	6,741.1			1	6,741.1				
Дүн	2	11,211.8			2	11,211.8			-	-